

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

№	Төслийн нэр	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн нэр	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан зорилго, зорилт	Төслийн зорилго, зорилт	Төслийн гүйцэтгэл, явц
1	Төмрийн баяжмалыг хорголжлох үйлдвэр	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд 14 мега төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөний 11-т заасны дагуу Гангийн цогцолборыг ашиглалтад оруулна.	3.3.1.5.Түүхий эд, бүтээгдэхүүнийг анхан шатнаас гүн боловсруулах Кокс-химийн цогцолбор, Нүүрс-химийн цогцолбор, Зэс боловсруулах цогцолбор, Ган үйлдвэрлэлийн цогцолбор, Жоншны хүдэр боловсруулах цогцолбор, Барилгын материал үйлдвэрлэлийн цогцолбор зэрэг хүнд үйлдвэрүүдийг ашиглалтад оруулж, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн боловсруулна.	“Бор-Өндөр” УБҮ-ийн нойтон соронзон аргаар баяжуулсан төмрийн хүдрийн баяжмалыг хорголжлон нэмүү өртөг шингээх, экспортын шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, улмаар дотоодын металлургийн үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр хангах зорилготой. Тус үйлдвэр нь жилд 200.0 мянган тонн хорголж үйлдвэрлэх хүчин чадалтай.	- Хорголжин үйлдвэрлэх технологи туршилт, шинжилгээний ажлыг ШУТИС-ийн Механик Тээврийн Сургуулийн цутгуурын лабораторид стандарт болон чанарын шаардлага хангаж байгааг судалгааны үр дүнгээр баталгаажсан. - Үйлдвэр баригдах 27 га газрыг гэрчилгээжүүлэн авсан. - Хорголжин үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулагдан батлагдсан. - Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийгдэж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийгдсэн. - Үйлдвэрлэлийн технологийн туршилтын үр дүнд суурилан технологийн зураг хийлгэх.
2	Жонш баяжуулах цогцолбор	"Эрдэнэс Монгол" ХХК-ийн 2024-2028 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөний Нэгдлийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдэд Үйлдвэрлэл технологийн парк болон бусад боловсруулах үйлдвэрүүдийг барьж байгуулна.	"Жонш боловсруулах цогцолбор Бор-Өндөр УТП"-ийн хүрээнд: Хэнтийн аймгийн Бор-Өндөр сумын нутагт жонш баяжуулах, боловсруулах, химийн үйлдвэрлэл, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр "Бор-Өндөр" үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулж, жоншны ФФ-97 хувийн баяжмал, фторт устөрөгч, фторт хөнгөн цагаан, фторт бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөсөн.	Төслийн зорилго нь Монгол Улсын ашигт малтмалын боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх, илүү нэмүү өртөг шингэсэн экспортын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, үйлдвэрийн бүтээгдэхүүний өртөг бууруулах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд оршино. Бүтээгдэхүүний чанарыг өсгөн ФФ-97 маркийн баяжмалыг үйлдвэрлэх, цаашид химийн үйлдвэрүүдийн түүхий эд болох фторт устөрөгч, криолит зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх суурь нөхцөлийг хангана.	- Хайлуурын жоншны баяжмалаас хайлуурын хүчил гарган авах ТЭЗҮ урьдчилсан суурь судалгааны ажил хийгдэж байна. - Хайлуур жоншны баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулагдан батлагдсан. - Төслийн төлөвлөлтийн болон үнэлгээний бичиг баримтыг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ-д танилцуулан, "Хайлуур жоншны баяжуулах үйлдвэр" барих төслийг хэрэгжүүлэх, зохион байгуулалтын ажил хийгдэж байна.